

БАТЛАВ.

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.БАТЛУТ

БИЧИЛ ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭГ ДЭМЖИХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг. Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага:

Бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн төслийг боловсруулах дараахь хууль зүйн болон практик үндэслэл, шаардлага байна.

1.Хууль зүйн үндэслэл

Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн “Хөдөлмөрийн зах зээл” гэсэн бүлгийн Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес хэсгийн Зорилт 3.3-т “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, бизнес эрхлэх арга, ур чадварыг хөгжүүлж, жижиг, дунд бизнес эрхлэлтийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ”, Зорилтыг хэрэгжүүлэх үе шат, хүрэх үр дүн I үе шат (2021-2030)-ын 2-д “Бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих орчин бэхжиж, төлөвшсөн байна” 4-д “Нийгмийн бүх салбарт тэгш бус байдлыг багасгаж, дундаж орлоготой иргэдийн тоог нэмэгдүүлж, амьдралын чанарыг дээшлүүлнэ”, Зорилт 4.5-д “Олон улсад өрсөлдөх чадвартай бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хөгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлнэ” гэж, Засгийн газрын 2019 оны 156 дугаар тогтоолоор баталсан “Жижиг дунд үйлдвэрийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийн ангилал, дэмжлэгийг оновчтой болгох, дэмжигч байгууллагын эрх үүргийн талаарх эрх зүйн орчинг боловсронгуй болгох” гэж тус тус заажээ.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2.5.14-т “Бүтээн байгуулалтын томоохон төслүүдийн үр дүнд болон хувийн хэвшил, жижиг, дунд үйлдвэрлэл, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 150 мянган ажлын байр шинээр бий болгоно”, Улсын Их Хурлын 2021 оны 12 сарын 30-ны өдрийн 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ыг хэрэгжүүлэх эхний үе шатны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.2.8-т “Орон нутагт бизнесийн орчныг дэмжих, хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэдийг малжуулах болон бусад хөдөө аж ахуйн чиглэлийн жижиг бизнесийг төрөөс бодлогоор дэмжих” зэргээр төрөөс жижиг, дунд үйлдвэрт үзүүлэх дэмжлэгийг оновчтой болгох эрх зүйн орчинг бүрдүүлэхээр заасан нь хуулийн төсөл боловсруулах хууль зүйн үндэслэл болно.

2.Практик шаардлага

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн системд шилжсэнээс хойш хувийн хэвшил давамгайлан хөгжиж, улс орны нийгэм-эдийн засагт хувийн хэвшлийн оруулж буй хувь нэмэр жилээс жилд өсөн нэмэгдэж байна. 2020 оны байдлаар дотоодын нийт бүтээгдэхүүний 75 хувь, улсын төсвийн орлогын 80 орчим хувь, нэг сая гаруй ажлын байрыг хувийн хэвшил бий болгосон дүнтэй байна.

Монгол Улсад ойролцоогоор 80 мянган аж ахуйн нэгж улсын бүртгэлтэйгээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 86 хувь нь жижиг дунд үйлдвэрлэл (ЖДҮ) байна.

ЖДҮ нь 800 мянган хүн буюу Монгол Улсын нийт ажиллах хүчний 57 хувийг ажлын байраар хангаж байна¹.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуульд жилийн 300 саяас 1 тэрбум хүртэлх төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй, 10-50 хүнийг ажлын байраар хангадаг бизнесийг “**жижиг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч**”, харин 300 сая хүртэлх эргэлтийн хөрөнгөтэй 10 хүртэлх хүнийг ажлын байраар хангадаг бол “**бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч**” гэж тодорхойлдог.

Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй ЖДҮ-ийн 59 хувь буюу дийлэнх нь жилийн 50 хүртэлх сая төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй үйл ажиллагаа явуулдаг бичил бизнес эрхлэгчид байна.

Сүүлийн 2 жилийн байдлаар нийт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн дийлэнхийг бичил бизнес эрхлэгчид эзэлж байна. Тухайлбал, **2020 оны байдлаар нийт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн 84,51 %, 2021 онд 80,99 хувийг бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчид эзэлсэн байна**².

Урт хугацаанд үргэлжилсэн Ковид-19 цар тахлын хямрал, эдийн засгийн уналтаас үүдэн аж ахуйн нэгжүүд бичил бизнес эрхлэгчидэд илүү хүнд цохилтод өртөж, үйл ажиллагаагаа тогтвортой эрхлэх боломжгүй болж, ашиг орлогоо алдах хандлагатай байгаа тул цаашид бичил бизнес эрхлэлтийг дэмжих, оновчтой бодлогыг эрчимжүүлэх нь дэлхийн эдийн засгийн сэргэлтийг дэмжих, нийгмийн эрүүл мэнд, баялаг бүтээх, инновацийг хүртээмжтэй болгоход чиглэсэн бодлого хэрэгжүүлэхэд гол түлхэц болно гэж үзжээ.

Бичил бизнес эрхлэгчийг дэмжих хууль эрх зүйн орчныг сайжруулах зайлшгүй шаардлага буюу шалтгаан нөхцөлийг дараах байдлаар тодорхойлж байна.Үүнд:

1. **Ядуурлыг бууруулах** - Бичил бизнес эрхлэгч нь хөгжиж буй орнуудад ядуурлыг бууруулах хүчирхэг гол хэрэгсэл болдог³ бөгөөд хувь хүмүүс өөрсдийн жижиг бизнесээ байгуулснаар орлоготой болж, өөртөө болон тухайн орон нутагтаа ажлын байр бий болгож байдаг. Иргэдэд бизнес эрхлэх тодорхой төрлийн санаа төрдөг ч бизнесээ эхлүүлэхэд нь санхүүгийн олон төрлийн бэрхшээлээс авхуулаад бизнесийн орчин, хөрөнгийн зах зээл, гадаад худалдаа, тухайн салбарын хууль эрх зүйн орчны талаарх мэдлэг, мэдээлэл дутмагийн улмаас тухайн санаа бодитоор хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсдэг. Иймд бичил бизнес эрхлэгчдэд зориулсан, бизнес эрхлэлтийг дэмжих эрх зүйн орчинг сайжруулах шаардлага зүй ёсоор үүсдэг.
2. **Инноваци ба шинэ бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх** - Бичил бизнес эрхлэгчид амжилтанд хүрэхийн тулд асуудалд шинэ, өвөрмөц шийдлүүдийг гаргаж ирэн зах зээлд өрсөлддөг тул ихэвчлэн маш шинэлэг, бүтээлч байдаг. Энэ нь нийгэмд бүхэлдээ ашиг тусаа өгөх шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ, технологийг хөгжүүлэн нийгмийн амьдралыг сайжруулж байдаг.
3. **Санхүүгийн боловсрол олгох зөвлөгөө хөтөлбөр боловсруулах**-бичил бизнес эрхлэх сонирхолтой иргэд тухайн бизнесийн эхлүүлэхэд хэдий хэмжээний хөрөнгө мөнгө шаардагдах талаар бүрэн дүүрэн, бодитой санхүүгийн мэдлэг ур чадвар дутмаг байдаг.
4. **Өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх**- Олон төрлийн бичил бизнесийг дэмжсэнээр зах зээлд бодит өрсөлдөөн бий болж чанартай, хэрэглэгчийн таашаалд нийцсэн эрэлтэд бүтээгдэхүүн бий болох боломжтой. **Татварын хууль тогтоомж дутмаг**-Манай улсад дагаж мөрдөгдөж буй татварын

¹ Монголын бичил болон жижиг бизнес эрхлэгч эмэгтэйчүүдэд ковид-19 цар тахлын үзүүлж буй нөлөөллийн үнэлгээ-эцсийн тайлан. 2021 он

² Монгол Улсын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний талаарх лавлагаа, мэдээлэл, 4 дэх тал

³ Hulme, D., & Arun, T. (2009). Microenterprises, the Poorest and Development: Reviewing the Evidence. Journal of International Development, 21(8), 985–1008. <https://doi.org/10.1002/jid.1649>

хууль тогтоомжуудад бичил бизнес эрхлэгч буюу жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн татварын уян хатан бодлого байдаггүйн улмаас тухайн бизнес урт хугацаандаа амьтай байж чаддаггүй. Түүнчлэн татварын хууль тогтоомж хурдацтай өөрчлөгддөгийн улмаас бичил бизнес эрхлэгчид татвар төлөх сонирхол байдаггүй. **Гадаад худалдаа хийх нөхцөл боломж хязгаарлагдмал**-Зах зээлд бичил бизнес эрхлэгчидэд зориулсан хууль, эрх зүйн орчин дутмаг, хэрэгжилт сул байгаагийн улмаас шударга зах зээлийн өрсөлдөөн хомс, үүнээсээ хамааралтайгаар тухайн бараа бүтээгдэхүүний чанар олон улсын түвшинд өрсөлдөх байдал нь хязгаарлагдмал байна.

5. **Зах зээлийн орчны нөлөө**- Зардал, үр ашиг, эрсдэлээ нарийн тодорхойлж, тэнцвэржүүлж чаддаг банк, санхүүгийн зах зээлтэй байснаар санхүүгийн үйлчилгээний хүртээмж хангалттай түвшинд байна. Бодлого гаргагчид, зохицуулагч байгууллагууд зах зээлийн тогтвортой байдлыг хангахын тулд холбогдох эрх зүйн орчныг сайжруулж байх шаардлагатай.
6. **Зээлийн нөхцөл уян хатан бус**- Ихэнх улсад жижиг дунд үйлдвэрлэл бичил бизнесийг дэмжих зорилгоор олон төрлийн зээлийн үйлчилгээг санал болгодог ба энэ нь бичил бизнесийн амжилттай эрхлэхэд хамгийн чухал хөшүүрэг болж өгдөг. Манай улсад зээлийн хэд хэдэн төрөл байх бөгөөд нийт судалгаанд оролцсон бичил бизнес эрхлэгчдийн 78 хувь нь арилжааны банкны хэрэглээний зээл авдаг байна.
7. **Хөнгөлөлттэй зээлийн олдоц хомс**-Жижиг дунд бизнес эрхлэгчдэд олгох зээл хязгаарлагдмал, олдоц хомс байдаг нь бичил бизнес эрхлэгчдэд хүндрэл дагуулдаг ба Монгол банкнаас хийсэн судалгаагаар нийт жижиг дунд бизнес эрхлэгчдийн 17 хувь нь хөнгөлөлттэй зээлд хамрагдсан гэх тоон үзүүлэлт байна.
8. **Эдийн засгийн хамтрал үүсгэх орчин байхгүй**-Монгол Улсад дагаж мөрдөгдөж буй хууль тогтоомжоор бичил бизнес эрхлэгч нь хамтрал үүсгэх боломж нөхцөл хомс, дэмжих механизм байхгүй. Энэ нь тухайн төрлийн бизнес хөгжих боломжийг хязгаарлаж байна. Олон төрлийн хамтрал үүссэнээр нэг нь нөгөөгөө батлан даах хамтын үйл ажиллагаагаа өргөжүүлэх гэх зэрэг олон боломжууд нээгдэнэ.
9. **Зээлийн баталгааны сан**- Зээлийн батлан даалтын арга хэрэгслийг хөгжиж буй болон өндөр хөгжсөн улс орнуудад бүгдэд нь ижил түгээмэл ашигладаг. Уг бодлогын хэрэгсэлийг Солонгос, Нидерланд, Малайз, АНУ зэрэг улсууд амжилттай хэрэгжүүлдэг. Зээлийн батлан даалтын сан манай улсад бодит утгаараа хэрэгждэггүй бичил бизнес эрхлэгчид тухайн сангийн талаар тодорхой мэдээлэлгүй байдаг нь хязгаарлалтыг бий болгож байна.
10. **Урт хугацааны бодлого баримтлах**- Дотоодын хууль тогтоомжоор зөвхөн зээл олгох хүртэл харилцааг зохицуулсан байх бөгөөд тус харилцааг цааш хэрхэн өргөжүүлэх үр өгөөжийг хэрхэн тодорхойлох, санхүүжилтийг үр ашигтай уян хатан нөхцлөөр хэрхэн олгох талаар зохицуулсан урт хугацааны бодлого хязгаарлагдмал байна. Зээлийн үйлчилгээгээр дамжуулан Бичил бизнес эрхлэгчдийг санхүүжүүлэх арга хэрэгсэл нь хөгжиж буй улсуудад хамгийн түгээмэл ашиглагдаж байна.
11. **Богино хугацааны бодлого баримтлах**- Эдийн засгийн хямралын үед төрөөс бичил бизнес эрхлэгчдийг хамгаалах богино хугацааны бодлогын арга хэрэгсэлийг ашигладаг. Тухайлбал, Турк Улс бичил бизнес эрхлэгч эрхлэгчдэдээ хямралын үед хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгох аргыг ашиглаж байсан.
12. **Бичил бизнес эрхлэгчийг хөгжүүлэх стратеги боловсруулах**- Бичил бизнес эрхлэгчийг хөгжүүлэх стратегийг боловсруулахдаа нэн тэргүүнд санхүүгийн зах зээл, үйлчилгээний хүртээмж, чанарыг үнэлэх шаардлагатай. Уг үнэлгээнд эрэлт болон нийлүүлэлт талын тоон

мэдээлэлд суурилсан санхүүгийн үйлчилгээний хүртээмжийн судалгаа, санхүүгийн зах зээлийн дэд бүтэц, хууль, эрх зүйн зохицуулалтын орчны чанарын судалгаа зэрэг судалгаанууд багтана. Үнэлгээг хийснээр зах зээлийн дутагдалтай талыг тодорхойлох, бодлого, хяналтын уялдаа холбоотой байдал зэргийг үнэлэхээс гадна бодлогын интервенцийн үр нөлөөг тооцох боломжтой болох юм.

13. **Зах зээлийг дэмжсэн хууль, эрх зүйн орчныг бий болгох**-Хууль, эрх зүйн оновчтой зохицуулалт нь өрсөлдөөнийг нэмэгдүүлэх чухал байр суурьтай. Тухайлбал, Бичил бизнес эрхлэгчдэд зориулсан санхүүгийн үйлчилгээгээр тэргүүлдэг гадаадын банк, санхүүгийн байгууллагуудыг зах зээлд нэвтрүүлэх, санхүүгийн түрээс, факторингийн үйлчилгээг хөгжүүлэх зэрэг юм.
14. **Хөрөнгийн зах зээлийг өргөжүүлэх**- Хөрөнгийн зах зээлийн эрх зүйн зохицуулалтын орчныг сайжруулж үнэт цаасны зах зээл, институционал хөрөнгө оруулагчдыг дэмжсэнээр Бичил бизнес эрхлэгчдэд зориулсан зээлийн бүтээгдэхүүний хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой.
15. **Барьцааны боломжийг нэмэгдүүлэх**: Зээлд барьцаалж буй барьцаа хөрөнгийн бүртгэлийг сайжруулснаар хөрөнгийг ангилах, үнэлэх үйл ажиллагаа сайжрах бөгөөд зөвхөн үл хөдлөх хөрөнгөөс гадна хөдлөх хөрөнгө зээлийн барьцаанд ашиглагдах боломжтой болох юм.
16. **Үр ашигт төрийн оролцоо**- Төрөөс гаргаж буй бүхий л зохицуулалт, интервенц нь зах зээлийн хэрэгцээнд нийцсэн, цаг хугацааны хувьд тохиромжтой, зардал, үр ашгийг сайтар тооцсон, эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдөхөд уян хатан хариу үзүүлэхүйц байх шаардлагатай юм.

Жилийн борлуулалтын орлогын хэмжээгээр нь ангилж үзвэл 50 сая төгрөг хүртэл орлоготой бизнес эрхлэгчдийн тоо нийт жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн 48 хувийг эзэлж байна. Жижиг, дунд үйлдвэрлэлийн тухай хуулиар тодорхойлсон бичил бизнес эрхлэгчид нь 300 хүртэл сая төгрөгийн борлуулалтын орлоготой гэж байгаа боловч нийт ЖДҮ эрхлэгчдийн бараг 50 орчим хувь нь 50 хүртэл сая төгрөгийн борлуулалтын орлоготой этгээдүүд байна. Үүн дээр хувиараа бизнес эрхлэгч иргэдийг нэмбэл дээрх үзүүлэлт нэмэгдэнэ.

Гэтэл 2018-2020 оны байдлаар жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн зээлийн санхүүжилт, төслийн тоог харгалзаж үзвэл 2018 оны байдлаар 212 төсөлд 96.3 тэрбум төгрөгийн, 2019 оны байдлаар 451 төсөлд 47.4 тэрбум төгрөгийн, 2020 оны байдлаар 249 төсөлд 22.8 тэрбум төгрөгийн зээлийн санхүүжилтийг олгожээ. Энэ нь нэг төсөлд ногдох дундаж зээлийн хэмжээ 90-100 сая төгрөг болох нь харагдаж байгаа бөгөөд дээр дурдсан нийт ЖДҮ эрхлэгчдийн 50 орчим хувийг эзлээд байгаа бичил бизнес эрхлэгчдэд төрөөс үзүүлж байгаа зорилтот зээлийн санхүүжилт, дэмжлэг хүртээмжгүй байгаа нь харагдаж байна.

Иймд Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулиас бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн зохицуулалтыг тусгайлан авч үзэж Бичил үйлвэр, үйлчилгээг дэмжих тусгайлсан хуулийн төслийг боловсруулах шаардлага гарч байна. Үүнд:

1/ Бичил бизнес эрхлэгчдийн хүрээг тэлж, оновчтой тодорхойлох

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулиар "бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч" гэж зөвхөн аж ахуй нэгжийг хэлнэ гэж тодорхойлсон. Гэтэл заавал аж ахуй нэгж байгуулахгүйгээр бизнесийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах нь хамгийн түгээмэл хэрэглэгдэж байгаа арга хэрэгсэл юм. Ингэснээр бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих суурь

хуулийн зохицуулалтаас олон бизнес эрхлэгчид орхигдож буй нөхцөл байдал бий болоод байгаа тул бичил үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгч гэдэг нэр томъёонд хамаарагдах субъектийн хүрээг тэлэхийн зэрэгцээ зах зээлийн нөхцөл байдал, нийт ЖДҮ эрхлэгчдийн борлуулалтын орлогын хэмжээг харгалзан бодит нөхцөл байдалд тулгуурлан бичил бизнес эрхлэгч гэдгийг 50 хүртэл сая төгрөгийн борлуулалтын орлоготой этгээд хэмээн тодорхойлох нь зүйтэй гэж үзэж байна.

Өөрөөр хэлбэл заавал хуулийн этгээд байгуулахгүйгээр иргэн өөрөө бизнесээ эрхлэх, иргэд хамтран ажиллах гэрээний үндсэн дээр хуулийн этгээд байгууллахгүйгээр **“иргэдийн бүлэг”** хэлбээр бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжтой бөгөөд түүнийг бизнес эрхлэгчээр бүртгэн төрийн бодлогын болоод санхүүгийн дэмжлэг авах боломжийг бүрдүүлнэ.

2/ Төрөөс хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөр арга хэмжээг ил тод, хүртээмжтэй болгох, бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхижуулах тусгайлсан бие даасан хөтөлбөрийг гаргаж, хэрэгжилтийг хангуулах

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний цар хүрээ, хөгжлийн үе шат, бүс нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө, гадаад зах зээлд нэвтрэх чадамж, техник, технологийн байдлыг нь харгалзан төрөөс жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний зах зээлийн эрэлт, хэрэгцээ шаардлагыг үндэслэн жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх, сургах, давтан сургах тогтолцоог хөгжүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх, татварын хөнгөлөлт, чөлөөлт үзүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний борлуулалтад төрийн худалдан авалтаар дэмжлэг үзүүлэх, бизнесийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх, шинэ бүтээгдэхүүн хөгжүүлэх, бүтээмжийг нэмэгдүүлэх судалгааг дэмжих, техник, технологийн дэвшлийг дамжуулах, нутагшуулах, шинжлэх ухаан, технологийн судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх, кластерын хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг тухайн орон нутаг дахь түүхий эдийн болон ажиллах хүчний нөөц, чадавх бусад онцлогоос хамааран дэмжих, гадаад, дотоод зах зээлд нэвтрэхэд дэмжлэг үзүүлэх зэрэг дэмжлэгийг үзүүлж байна.⁴

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлүүлэх асуудлыг тухайн төрлийн татварын хуулиар нарийвчлан зохицуулж байна⁵.

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нь төрөөс хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд хамрагдах, санхүүгийн дэмжлэг авах эрхтэй байх хэдий ч уг эрхээ хэрэгжүүлэхэд мэдээлэл дутмаг, нийтэд тэгш хүртээмжгүй байна.

Тиймээс төрөөс хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, зээлд хамрагдах тэгш байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх, зээл олгох үйл явцыг нээлттэй ил тод болгох цогц арга хэмжээг авч хэрэгжүүлснээр дээрх сөрөг нөхцөл байдал арилна.

Тэр дундаа бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн хууль, эдийн засаг, санхүү, маркетинг, менежмент зэрэг олон салбарын мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, мэдээллийн ил тод байдлыг хангахад чиглэсэн бие даасан цогц хөтөлбөр хэрэгжүүлснээр бичил бизнес эрхлэгчид ихээр нэмэгдэнэ. Холбогдох, хамгийн зөв мэдээллийг түргэн шуурхай өгснөөр бизнес эрхлэгчид үндэслэлтэй шийдвэр гаргаж, үйл ажиллагааны илүү сайн стратеги боловсруулж, бизнесийн ерөнхий гүйцэтгэлээ сайжруулж чадна. Түүнчлэн иймэрхүү хөтөлбөр нь бизнесийн өсөлтийг дэмжиж, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, эдийн засгийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулдаг ба хувиараа бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжсэнээр эдийн засгийн өсөлт, тогтвортой байдлыг хангахад чухал хөшүүрэг болдог.

⁴ Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг

⁵ Аж ахуй нэгжийн орлогын татварын тухай хуульд заасан албан татварын хувь, хэмжээ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасан албан татварын чөлөөлөлт гэх мэт

Иймд санхүүгийн мэдлэг мэдээллийг сайжруулах бие даасан хөтөлбөрийг бий болгон хэрэгжүүлснээр үйлдвэрлэл, үйлчилгээ, бизнестээ хэрэгцээтэй санхүүжилтийг зөв тодорхойлох, татвар санхүүгийн талаар мэдлэг мэдээлэл нь сайжирч үр ашигтай хөрөнгө оруулалт хийх нөхцөл боломжийг бичил бизнес эрхлэгдэд олгоно.

3/ Төрөөс үзүүлэх дэмжлэгийг оновчтой болгох, татварын таатай орчныг бүрдүүлэх

Бичил бизнес эрхлэгчдийн хувьд нэн түрүүнд тулгардаг, хамгийн их хөрөнгө оруулалт шаарддаг зүйл нь үйлдвэрлэл, үйлчилгээний тоног төхөөрөмжийн асуудал байдаг. Дотоодын үйлдвэрлэл хангалттай хөгжөөгүй улс орны хувьд бизнес эрхлэгчдийг бодитойгоор дэмжих нэн шаардлагатай байна. Цар тахлын улмаас хил гаалийн хаалттай нөхцөл байдлаас болж үнийн хөөрөгдөлд ороод байгаа импортоор оруулж ирдэг тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл, шаардлагатай түүхий эд бүтээгдэхүүнийг Гаалийн болон Нэмэгдсэн өртөгийн албан татвараас тодорхой хугацаанд чөлөөлөх нь бизнес эрхлэгчдэд бодит дэмжлэг болно.

Манай улсын хувьд тулгамдаад байгаа гол асуудлын нэг нь хөдөлмөрийн харилцаан дахь хүний нөөц болон ажиллах хүчний чадамжийн асуудал байдаг. 2021 Хөдөлмөрийн тухай хуулийг шинэчлэн найруулж хөдөлмөрийн олон талт харилцааг бий болгосон. Жижиг, дунд үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдийн ангиллын шалгуур болох ажлын байрны асуудал дээр чухалчлан анхаарах шаардлагатай. Тухайлбал, бизнес эрхлэгчдийн хувьд бизнесийн үйл ажиллагаагаа өргөжин тэлэх, санхүүжилтээ оновчтой зүйлд зарцуулах, ажилтнууддаа хангалттай хэмжээний цалин хөлс олгох зэрэгт томоохон хүндрэлийн нэг нь Нийгмийн даатгалын шимтгэлийн асуудал юм. Иймд анхлан үүсэн байгуулагдаж буй бичил бизнес эрхлэгчдийг ажил олгогчдийн нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх зохицуулалтыг нэмэлтээр оруулснаар төрөөс бодлогын болоод санхүүгийн, хөдөлмөрийн харилцаанд үзүүлж буй томоохон дэмжлэг хөшүүрэг болж өгнө.

4/ Төрийн бодлогын дэмжлэгээг үйлдвэр, үйлчигээний борлуулалтыг өргөтгөх

Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгч нарын үйлдвэрлэсэн эцсийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжих, нэмэгдүүлэх нь хамгийн чухал асуудлын нэг болоод байгаа бөгөөд нөгөө талаас үйлдвэрлэгч нарын хөдөлмөрийн бүтээмж, бүтээгдэхүүний чанар, нэр төрлийг сайжруулах шаардлагатай байна. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны хүрээнд уг дэмжлэг үзүүлэх асуудлыг зохицуулсан байдгийг бичил бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авах байдлаар зохицуулалт хийнэ.

Үүний зэрэгцээ улс орны хөгжил дэвжилд хэрэгтэй дэд бүтцийн болоод нийгмийн суурь үйлчилгээний томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх зорилго бүхий Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль 2022 онд шинэчлэгдэн батлагдсан. Тус хуулийн хүрээнд хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн дагуу Засгийн газраас гэрээ байгуулахдаа тодорхой хувийн худалдан авалтийн үйл ажиллагааг дотоодын үйлдвэрлэгчид, тэр дундаа бичил бизнес эрхлэгчдийн бүтээгдэхүүн үйлчилгээнээс худалдан авахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг нэмснээр томоохон төсөл хөтөлбөрүүдийг дагаад бичил бизнес хөгжих боломжийг бий болгоно.

5/ Зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэх

Сүүлийн 2 жилийн байдлаар нийт ЖДҮ эрхлэгчдийн дийлэнхийг буюу 80 орчим хувийг бичил ЖДҮ эрхлэгчид эзэлж байна гэж дээр дурдсан. Гэтэл тус бичил

бизнес эрхлэгчдийн хувьд эргэлтийн хөрөнгөө сайжруулах төслөө хэрэгжүүлэхэд дутагддаг санхүүжилтийг авахад хамгийн дутагдалтай нэг асуудал нь зээл авахад шаардагддаг барьцаа хөрөнгийн асуудал юм. Өнөөгийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн хүрээнд Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас зээлийн санхүүжилт авахад заавал барьцаа хөрөнгө, тэр дундаа үл хөдлөх хөрөнгийн барьцааг шаардаж байгаа. Энэ нь дөнгөж бизнесийн үйл ажиллагаа эхлүүлж байгаа бичил бизнес эрхлэгчдэд ихээхэн хүндрэлийг бий болгодог.

Иймээс бичил бизнес эрхлэгчдийн эхлэлтийн хөрөнгийн санхүүжилт болох 5 хүртэл сая төгрөгийн санхүүжилтийг барьцаагүйгээр олгох, зөвхөн үл хөдлөх хөрөнгөөр барьцаа хөрөнгө хийдэг зохицуулалтыг өргөтгөн, хөдлөх хөрөнгө болон хамтран ажиллах гэрээний хүрээнд ажиллаж байгаа иргэд баталгаа гаргах, барьцаа хөрөнгө гаргах зэрэг зохицуулалтын өргөн хувилбаруудыг хууль, журмын хүрээнд оруулснаар санхүүжилт авах боломжийг нэмэгдүүлэх юм.

Мөн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн зээлийн санхүүжилт нь түлхүү жижиг, дунд бизнес эрхлэгчдийн ангилалд буюу 50 сая төгрөгөөс дээш борлуулалтын орлоготой этгээдүүдэд олгогдож байгаа тул зорилтот хэсгийн бичил бизнес эрхлэгчдийн эхлэлтийн хөрөнгийн болон үйл ажиллагаагаа өргөжүүлэх хөрөнгө оруулалтын санхүүжилт болгох Бичил бизнесийг дэмжих санг тусгайлан байгуулж санхүүгийн дэмжлэгийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

Хоёр. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ:

Бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжих тухай хуулийн төсөлд бичил бизнес эрхлэгчдийн хэмжээ хязгаарыг тодорхойлох, бизнесийн үйл ажиллагааг дэмжих бодлогын хөтөлбөрүүд гаргах, санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх зээл авах боломжийг нэмэгдүүлж, татварын болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг, үзүүлэх, төрийн байгууллагын эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулна.

Хуулийн төсөлд дараах харилцааг зохицуулахаар тусгана. Үүнд:

Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилго, зорилт, нэр томьёонд бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийг 50 сая хүртэл төгрөгийн борлуултын орлоготой, иргэн, иргэдийн бүлэг, аж ахуйн нэгж хэмээн тодорхойлно.

Хоёрдугаар бүлэгт бичил үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчийн бүртгэлтэй холбоотой болон хамаарахгүй этгээдийг нарийвчлан зааг ялгааг тодорхой болгосноор зээл, дэмжлэг эзнээ олох боломж нэмэгдэнэ.

Гуравдүгээр бүлэгт төрөөс бичил үйлдвэр, үйлчилгээний салбарын харилцаанд оролцогчийн эрх, үүргийн талаарх зохицуулалтыг тусгана.

Дөрөвдүгээр бүлэгт бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих төрийн бодлого, дэмжлэгийн хэлбэр, кластерийн үйл ажиллагаа, бичил үйлдвэр, үйлчилгээг дэмжих сан болон цахим мэдээллийн сангийн талаарх зүйл, заалтыг тусгана.

Тавдугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэрийн талаарх төрийн болон орон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх, зохицуулалтыг тусгана.

Зургаадугаар бүлэгт жижиг, дунд үйлдвэрийн тухай хууль тогтоомжийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага зэрэг бусад зохицуулалтыг тусгана.

Гурав. Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засгийн үр дагавар

Хуулийн төслийн нэмэлт өөрчлөлтөөр бичил бизнес эрхлэгч гэсэн нэр томъёоны хүрээнд эрх зүйн зохицуулалт хийснээр төрийн санхүүжилтийн томоохон дэмжлэгийг хэрэгжүүлэх Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас аль ч түвшний бичил бизнес эрхлэгчид дэмжлэг санхүүжилт авах боломж нэмэгдэнэ. Мөн хамтын санхүүжилтийн зохицуулалтыг оруулж ирснээр санхүүжилтийн нэмэлт хувилбарууд нэмэгдэнэ. Мөн татварын болон нийгмийн даатгалын бодлогын зохицуулалтаар бичил бизнес эрхлэгчдэд тусгайлан дэмжлэг үзүүлснээр ажлын байр нэмэгдэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодит үр нөлөө гарна.

Дөрөв. Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар:

Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуультай нийцүүлэн боловсруулах болно.

Уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан, Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, Гаалийн татвараас чөлөөлөх тухай хууль, Нэмэгдсэн өртөгийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн төслийг боловсруулна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ